

**ӨМНӨХ ҮГ**

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төвтэй хамтран Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 21 дэх дугаарыг бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн **“Судалгаа”** хэсэгт шилжигч ажилчдад чиглэсэн БНСУ-ын хууль эрх зүйн орчин, Монголоос шилжин очсон ажилчдын үзүүлж буй нийгэм эдийн засгийн үр нөлөө, Монголын орон сууцны зах зээлийн хэрэглэгчийн зан төлвийн судалгаа, Монгол хэрэглэгчийн сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн өнөөгийн байдал зэрэг судалгааны ажлуудын үр дүн, Хувь хүний орлогын албан татварын бодлого, зохицуулалтын асуудалд хийсэн дүн шинжилгээ, санал зөвлөмжийг танилцуулж байна.

**“Сургалт”** хэсгээс *“Хүн амын моментумын тухай ойлголт”*-ын талаар мэдлэг олж, оюуны цар хүрээгээ тэлээрэй.

Сэтгүүлийнхээ **“English”** хэсэгт Монголын хүн амын төрөлтөд нөлөөлөгч завсрын хүчин зүйлс, Монголын эмч нарын ажлын байранд дах стресс, Монголын хүн амын хөгшрөлт ба нийгмийн халамж харилцаа, Хүнс тэжээлийн илчлэг байдлын эрэлтийн уян хатан байдал Монголд, суурь тэтгэврийн даатгалыг сайжруулах арга зүйн зарим асуудлууд зэрэг гүнзгийрүүлсэн шинжилгээ бүхий судалгааны ажлуудын үр дүнг нийтэллээ.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Яаманд сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

**РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ**